



**НИЙСЛЭЛИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ
ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР**

2015 оны 03 сарын 02 өдөр

Дугаар 15/60

Улаанбаатар хот

Ахлах нягтлан бодогч, хошууч Ш.Саранчимэг,
кассын нярав, ахлагч Б.Оюунчимэг нарт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт,
72 дугаар зүйлийн 72.4 дэх заалтыг тус тус үндэслэн ДААЛГАХ НЬ:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу шийдвэр гүйцэтгэгч нь хүлээн авсан бэлэн мөнгийг төв суурин газарт 24 цагийн, хөдөө орон нутагт 7 хоногийн дотор төлбөр авагчид олгох буюу шийдвэр гүйцэтгэх албаны дансанд шилжүүлэх ёстой. Иймд шийдвэр гүйцэтгэгчийг албаны дансанд бэлэн мөнгө тушаах нөхцөл бололцоогоор хангаж, шийдвэр гүйцэтгэгч албаны дансанд бэлнээр хураасан төлбөрийн мөнгө тушаахаар дуудсан үед 24 цагаар бэлэн байхыг кассын нярав, /ахлагч Б.Оюунчимэг/-т үүрэг болгосугай.

2. Кассын хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж, шийдвэр гүйцэтгэгчийг бэлэн мөнгө тушаах нөхцөл бололцоогоор хангах явдалд хяналт тавихыг ахлах нягтлан бодогч, /хошууч Ш.Саранчимэг/-т үүрэг болгосугай.

3. Албан даалгаврын биелэлтийг хангаж ажиллаагүй, хангалтгүй биелүүлсэн тохиолдолд хуульд заасан хариуцлага ногдуулахыг мэдэгдье.

ДАРГА, ДЭД ХУРАНДАА

Т.ЭНХБАТ